



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 5 сарын 23 өдөр

Дугаар 189

Улаанбаатар хот

Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн  
байгуулах баримт бичгийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх тухай журам”-ын 2.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Силк рөүд Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулж буй “Кинг Фанд” хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т үүрэг болгосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Силк рөүд Ассет Менежмент ҮЦК” ХХК /Ц.Ганзориг/-д үүрэг болгосугай.

1/ Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг зохих журмын дагуу гүйцэтгэж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөн, мэргэжлийн ёс зүйтэй ажиллах;

2/ Үүсгэн байгуулсан “Кинг Фанд” хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, сангийн нэгж эрхийн танилцуулгад нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд Хороонд тухай бүр мэдэгдэн холбогдох баримт бичгийг бүртгүүлэх;

3. Тогтоол батлагдсанаас хойш ажлын 15 хоногийн дотор Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН